



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дулааны техник, үйлдвэрлэлийн экологийн хүрээлэнгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СНАГ-2025/033/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Улаанбаатар хот
2025 он

Санхүү, Нийцлийн аудитын газрын захирал,
тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naramchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: П.Чанцалдулам
Утас: 261885 Цахим хаяг: chantsaldulamp@audit.mn
Аудитор: Г.Тэлмүүн
Утас: 261740 Цахим хаяг: telmuung@audit.gov.mn
Мишээл-Од Аудит ХХК-ийн захирал: Т.Одончимэг
Утас: 70169029 Цахим хаяг: info@misheelodaudit.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2025.02.25 № 07/828
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дулаан техник, үйлдвэрлэлийн экологийн хүрээлэнгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитын гол асуудал

Нэмэлт санхүүжилтийн дансанд төсвийн байгууллагын үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоос 206,847.4 мянган төгрөг, дээд шатны төсөв захирагчийн төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан 29,601.2 мянган төгрөг, нийт 236,448.6 мянган төгрөгийн санхүүжилт авч, төслийн хүрээнд 227,337.4 мянган төгрөгийн зарцуулалт гаргасан байна.

Бусад асуудал

Хүрээлэн нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаа хуулийн хугацаандаа ирүүлж, Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д заасны дагуу аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд шаардсан мэдээлэл, баримт бичгийг саадгүй гаргаж ирүүлсэн.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	40,583,984.14	41,816,295.00
33	АВЛАГА	190,189.14	-
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	190,189.14	-
34	УРЬДЧИЛГАА	16,200,000.00	4,770,000.00
34600	Урьдчилж гарсан зардал	16,200,000.00	4,770,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	24,193,795.00	37,046,295.00
351	Түүхий эд материал	-	2,790,000.00
35110	Тусгай зориулалттай материал	-	2,790,000.00
354	Хангамжийн материал	24,193,795.00	34,256,295.00
35410	Бичиг хэргийн материал	514,600.00	1,210,850.00
35420	Аж ахуйн материал	19,800.00	-
35450	Барилгын засварын материал	-	13,750.00
35470	Бусад хангамжийн материал	23,659,395.00	33,031,695.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,013,112,918.84	1,065,169,181.83
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,013,112,918.84	1,065,169,181.83
392	Биет хөрөнгө	959,261,918.84	1,011,618,181.83
39201	Барилга, байгууламж, орон сууц	679,035,860.00	679,035,860.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(144,147,765.61)	(165,422,777.53)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	1,512,969,589.29	1,114,767,876.88
39206	Хуримтлагдсан элэгдэл	(1,098,244,461.50)	(634,087,332.84)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	19,557,800.00	16,102,000.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(16,258,103.68)	(5,026,445.06)
39214	Бусад үндсэн хөрөнгө	3,000,000.00	3,000,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(879,999.66)	(979,999.62)
39217	Ном	4,229,000.00	4,229,000.00
393	Биет бус хөрөнгө	53,851,000.00	53,551,000.00
39301	Програм хангамж	2,080,000.00	1,200,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,480,000.00)	(900,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	53,251,000.00	53,251,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,053,696,902.98	1,106,985,476.83
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,053,696,902.98	1,106,985,476.83
51	Засгийн газрын хувь оролцоо	1,053,696,902.98	1,106,985,476.83
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/	319,956,570.00	319,956,570.00
51101	Өмч: - төрийн	319,956,570.00	319,956,570.00
512	Хуримтлагдсан үр дүн	299,057,921.26	352,346,495.11
51210	Өмнөх үеийн үр дүн	318,728,990.51	299,057,921.26
51220	Тайлант үеийн үр дүн	(19,671,069.25)	53,288,573.85
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	434,682,411.72	434,682,411.72
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,053,696,902.98	1,106,985,476.83

Дулааны техник үйлдвэрлэлийн экологийн хүрээлэнгийн 2024 оны санхүүгийн тайлан
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл /төгрөгөөр/
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,179,727,357.00	1,341,193,818.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	60,631,810.00	58,450,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	60,631,810.00	58,450,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	42,656,490.00	58,450,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		70,000.00
1200017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	42,656,490.00	58,380,000.00
1200018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал	17,975,320.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,119,095,547.00	1,282,743,818.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	934,353,000.00	1,046,295,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	934,353,000.00	1,046,295,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	184,742,547.00	236,448,618.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	24,286,800.00	29,601,200.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	160,455,747.00	206,847,418.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,199,398,426.25	1,287,905,244.15
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,199,398,426.25	1,287,905,244.15
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	970,586,403.21	1,211,751,138.73
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	568,086,584.16	784,130,053.25
210101	Үндсэн цалин	389,115,664.95	603,301,112.25
210102	Нэмэгдэл	66,938,688.81	78,883,925.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	62,671,909.00	70,164,426.00
210104	Урамшуулал	49,360,321.40	31,780,590.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	64,610,301.86	66,553,289.12
210201	Тэтгэврийн даатгал	48,404,181.94	46,037,889.47
210202	Тэтгэмжийн даатгал	5,675,405.32	6,512,315.18
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,509,525.69	4,274,963.00
210204	Ажилгүйдлийн даатгал	445,835.30	1,524,745.40
210205	Эрүүл мэндийн даатгал	5,575,353.61	8,203,376.07
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	50,958,950.48	55,591,916.24
210301	Гэрэл, цахилгаан	50,958,950.48	55,591,916.24
2104	Хангамж, бараа материалын зардал	14,489,775.09	17,896,536.00
210401	Бичиг хэрэг	1,059,650.00	4,030,700.00
210402	Тээвэр, шатахуун	1,885,440.00	2,773,294.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,025,745.09	3,032,442.00
210404	Ном, хэвлэл	640,000.00	7,200,300.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	993,000.00	540,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,885,940.00	319,800.00
2105	Нормативт зардал	3,676,880.00	-

**Дулааны техник үйлдвэрлэлийн экологийн хүрээлэнгийн 2024 оны санхүүгийн тайлан
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан**

210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,384,700.00	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,292,180.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,745,550.00	10,849,750.00
210604	Урсгал засвар	5,745,550.00	10,849,750.00
2107	Томилолт, зочны зардал	2,912,300.00	12,354,800.00
210702	Дотоод албан томилолт	2,472,300.00	12,354,800.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	440,000.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	120,678,772.22	117,451,939.12
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	118,335,530.22	112,451,939.12
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,000,000.00	5,000,000.00
210807	Газрын төлбөр	343,242.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	139,427,289.40	146,922,855.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,726,180.00	13,575,785.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,360,070.00	2,000,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	130,341,039.40	131,347,070.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	228,812,023.04	76,154,105.42
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	228,812,023.04	76,154,105.42
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	217,106,411.26	67,042,908.77
213305	НС-ийн төвлөрүүлэх шилжүүлэг	11,705,611.78	9,111,196.65
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(19,671,069.25)	53,288,573.85
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(19,671,069.25)	53,288,573.85

Дулааны техник үйлдвэрлэлийн экологийн хүрээлэнгийн 2024 оны санхүүгийн тайлан
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,119,095,547.00	1,282,813,818.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	70,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	-	70,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	70,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	70,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,119,095,547.00	1,282,743,818.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	934,353,000.00	1,046,295,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	934,353,000.00	1,046,295,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	184,742,547.00	236,448,618.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	24,286,800.00	29,601,200.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	160,455,747.00	206,847,418.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,091,528,947.00	1,157,790,485.01
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,091,528,947.00	1,157,790,485.01
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	862,716,923.96	1,081,636,379.59
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	568,086,584.16	784,130,053.25
210101	Үндсэн цалин	389,115,664.95	603,301,112.25
210102	Нэмэгдэл	66,938,688.81	78,883,925.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	62,671,909.00	70,164,426.00
210104	Урамшуулал	49,360,321.40	31,780,590.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	64,663,387.01	66,363,099.98
210201	Тэтгэврийн даатгал	48,457,267.09	45,747,023.47
210202	Тэтгэмжийн даатгал	5,675,405.32	6,512,315.18
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,509,525.69	4,375,639.86
210204	Ажилгүйдлийн даатгал	445,835.30	1,524,745.40
210205	Эрүүл мэндийн даатгал	5,575,353.61	8,203,376.07
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	50,958,950.48	55,591,916.24
210301	Гэрэл, цахилгаан	50,958,950.48	55,591,916.24
2104	Хангамж, бараа материалын зардал	18,681,350.09	19,264,372.00
210401	Бичиг хэрэг	1,516,450.00	2,109,500.00
210402	Тээвэр, шатахуун	1,885,440.00	1,838,430.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,025,745.09	3,032,442.00
210404	Ном, хэвлэл	640,000.00	9,835,500.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	993,000.00	540,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	10,620,715.00	1,908,500.00
2105	Нормативт зардал	3,676,880.00	1,740,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,384,700.00	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,292,180.00	1,740,000.00

Дулааны техник үйлдвэрлэлийн экологийн хүрээлэнгийн 2024 оны санхүүгийн тайлан
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	11,205,150.00	18,647,985.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	259,600.00	13,011,985.00
210604	Урсгал засвар	10,945,550.00	5,636,000.00
2107	Томилолт, зочны зардал	2,912,300.00	13,289,664.00
210702	Дотоод албан томилолт	2,472,300.00	13,289,664.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	440,000.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	131,678,772.22	114,421,939.12
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	129,335,530.22	109,421,939.12
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,000,000.00	5,000,000.00
210807	Газрын төлбөр	343,242.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	10,853,550.00	8,187,350.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,493,480.00	6,187,350.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,360,070.00	2,000,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	228,812,023.04	76,154,105.42
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	228,812,023.04	76,154,105.42
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	217,106,411.26	67,042,908.77
213305	НС-ийн төвлөрүүлэх шилжүүлэг	11,705,611.78	9,111,196.65
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	27,566,600.00	125,023,332.99
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	-	-
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	27,566,600.00	125,023,332.99
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	27,566,600.00	125,023,332.99
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	27,566,600.00	125,023,332.99
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(27,566,600.00)	(125,023,332.99)
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан
2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	319,956,570.00	434,682,411.72	631,971,352.51	1,386,610,334.23
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(313,242,362.00)	(313,242,362.00)
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	319,956,570.00	434,682,411.72	318,728,990.51	1,073,367,972.23
7	Тайлант үеийн үр дүн	-	-	(19,671,069.25)	(19,671,069.25)
11	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	319,956,570.00	434,682,411.72	299,057,921.26	1,053,696,902.98
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	319,956,570.00	434,682,411.72	299,057,921.26	1,053,696,902.98
18	Тайлант үеийн үр дүн	-	-	53,288,573.85	53,288,573.85
19	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	319,956,570.00	434,682,411.72	352,346,495.11	1,106,985,476.83

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,046,295,200.00	979,322,291.23	66,972,908.77	93.6
УРСГАЛ ЗАРДАЛ	1,046,295,200.00	979,322,291.23	66,972,908.77	93.6
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,046,295,200.00	979,322,291.23	66,972,908.77	93.6
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	785,856,000.00	740,690,539.25	45,165,460.75	94.3
Үндсэн цалин	584,456,500.00	559,861,598.25	24,594,901.75	95.8
Нэмэгдэл	78,991,900.00	78,883,925.00	107,975.00	99.9
Унаа хоолны хөнгөлөлт	109,204,900.00	70,164,426.00	39,040,474.00	64.3
Урамшуулал	13,202,700.00	31,780,590.00	(18,577,890.00)	240.7
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	70,357,100.00	65,097,730.75	5,259,369.25	92.5
Тэтгэврийн даатгал	43,002,800.00	44,481,654.24	(1,478,854.24)	103.4
Тэтгэмжийн даатгал	6,838,600.00	6,512,315.18	326,284.82	95.2
ҮОМШӨ-ний даатгал	3,419,300.00	4,375,639.86	(956,339.86)	127.9
Ажилгүйдлийн даатгал	3,419,300.00	1,524,745.40	1,894,554.60	44.6
Эрүүл мэндийн даатгал	13,677,100.00	8,203,376.07	5,473,723.93	59.9
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	50,547,500.00	40,506,116.24	10,041,383.76	80.1
Гэрэл, цахилгаан	36,022,300.00	40,506,116.24	(4,483,816.24)	112.5
Түлш, халаалт	12,360,600.00	-	12,360,600.00	-
Цэвэр, бохир ус	2,164,600.00	-	2,164,600.00	-
Хангамж, бараа материалын зардал	10,058,600.00	9,404,072.00	654,528.00	93.5
Бичиг хэрэг	1,676,700.00	1,159,500.00	517,200.00	69.2
Тээвэр, шатахуун	1,853,200.00	1,838,430.00	14,770.00	99.2
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,327,900.00	3,032,442.00	295,458.00	91.1
Ном, хэвлэл	929,100.00	925,200.00	3,900.00	99.6
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,701,600.00	540,000.00	1,161,600.00	31.7
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	570,100.00	1,908,500.00	(1,338,400.00)	334.8
Нормативт зардал	3,448,900.00	1,740,000.00	1,708,900.00	50.5
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,358,400.00	-	1,358,400.00	-
Хоол, хүнс	-	-	-	-
Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,090,500.00	1,740,000.00	350,500.00	83.2
Эд хогшил, урсгал засварын зардал	25,636,600.00	25,388,198.94	248,401.06	99.0
Багаж, техник, хэрэгсэл	20,000,000.00	19,752,198.94	247,801.06	98.8
Урсгал засвар	5,636,600.00	5,636,000.00	600.00	99.9
Томилолт, зочны зардал	2,312,000.00	1,950,000.00	362,000.00	84.3
Дотоод албан томилолт	1,754,600.00	1,950,000.00	(195,400.00)	111.1
Зочин төлөөлөгч хүлээн авах	557,400.00	-	557,400.00	-

**Дулааны техник үйлдвэрлэлийн экологийн хүрээлэнгийн 2024 оны санхүүгийн тайлан
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан**

Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	90,515,600.00	88,358,284.05	2,157,315.95	97.6
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	87,667,000.00	87,358,284.05	308,715.95	99.6
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,010,100.00	1,000,000.00	10,100.00	99.0
Газрын төлбөр	1,414,200.00	-	1,414,200.00	-
Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	424,300.00	-	424,300.00	-
Бараа үйлчилгээний бусад зардал	7,562,900.00	6,187,350.00	1,375,550.00	81.8
Бараа үйлчилгээний бусад зардал	7,562,900.00	6,187,350.00	1,375,550.00	81.8
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,046,295,200.00	979,322,291.23	66,972,908.77	93.6
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,046,295,200.00	979,252,291.23	67,042,908.77	93.6
Улсын төсвөөс санхүүжих	1,046,295,200.00	979,252,291.23	67,042,908.77	93.6
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	-	70,000.00	(70,000.00)	-
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	70,000.00	(70,000.00)	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	-	-
ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	-	-	-	-
БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	-	100.0
Төсвийн байгууллага	1	1	-	100.0
АЖИЛЛАГСДЫН ТОО	48	-	-	-
Удирдах ажилтан	1	1	-	100.0
Гүйцэтгэх ажилтан	43	33	10	76.7
Үйлчлэх ажилтан	4	4	-	100.0
Гэрээт ажилтан	-	-	-	-

Дулааны техник үйлдвэрлэлийн экологийн хүрээлэнгийн 2024 оны санхүүгийн тайлан
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	236,148,618.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	236,148,618.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	236,148,618.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	43,439,514.00
210101	Үндсэн цалин	-	43,439,514.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	-	1,265,369.23
210201	Тэтгэврийн даатгал	-	1,265,369.23
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	-	15,085,800.00
210301	Гэрэл, цахилгаан	-	15,085,800.00
2104	Хангамж, бараа материалын зардал	-	9,860,300.00
210401	Бичиг хэрэг	-	950,000.00
210402	Тээвэр, шатахуун	-	8,910,300.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	39,066,585.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	32,563,885.00
210602	Тавилга	-	6,502,700.00
2107	Томилолт, зочны зардал	-	11,339,664.00
210702	Дотоод албан томилолт	-	11,339,664.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	105,280,189.12
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	101,280,189.12
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	4,000,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	2,000,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	2,000,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	9,111,196.65
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	9,111,196.65
261090	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	9,111,196.65
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	236,448,618.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	236,448,618.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	206,847,418.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	29,601,200.00
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	-	-
11000	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
12000	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

3. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

3.1 Аудитаар нийт 277,668.1 мянган төгрөгийн 9 алдаа¹ илэрснээс аудитын явцад 277,668.1 мянган төгрөгийн алдааг залрууллаа.

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/ Үүнээс			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй	
							Тоо	Дүн	Тоо	Дүн
Цахим татварын системийн татварын тодорхойлолтод 6,041.2 мянган төгрөгийн татварын өрийн үлдэгдэлтэй байгаа боловч санхүүгийн тайланд татварын өрийн үлдэгдэлгүйгээр тайлагнасан	1	6,041.2	1	6,041.2	-	-	1	6,041.2	-	-
Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн зардлын ангилал, тооцоог шалгахад Шуудан холбоо, интернэтийн төлбөрийн 505.4 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлын 1,264.8 мянган төгрөг, нийт 1,770.2 мянган төгрөгийн гүйлгээг аккурэл сууриар бүртгээгүй, шууд зардлын дансанд бүртгэсэн	1	1,770.2	-	-	1	1,770.2	1	1,770.2	-	-
Авлага, өглөгийн дансыг харилцагч бүрээр шалгахад УБЦТС ТӨХК харилцагчаас 1-8-р сард 19,485.7 мянган төгрөгийн нэхэмжлэх ирснээс 22,505.4 мянган төгрөгийг төлж, 3,019.7 мянган өгрөгийн илүү төлөлттэй байх тооцоо гарсан боловч санхүүгийн тайлангаар УБЦТС-нд өр, авлага байхгүй	1	3,019.7	1	3,019.7	-	-	1	3,019.7	-	-
Нийт 13 ажилтны эд хариуцагчийн карт хөтлөгдөөгүй	1	-	1	-			1	-	-	-
2024 онд худалдан авсан 5 ширхэг 14,735.5 мянган төгрөгийн дэлгэц болон процессорыг нийлүүлэн компьютер гэж, мөн 5 ширхэг 2,750.0 мянган төгрөгийн сандал ширээг тус тусад нь бүртгээгүй нийлүүлэн орлогод авч бүртгэсэн	1	17,485.5	-	-	1	17,485.5	1	17,485.5	-	-

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

Дулааны техник үйлдвэрлэлийн экологийн хүрээлэнгийн 2024 оны санхүүгийн тайлан төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

50 ширхэг 224,500.1 мянган төгрөгийн хөрөнгийн нэршлийг алдаатай бүртгэсэн	1	224,500.1	-	-	1	224,500.1	1	224,500.1	-	-
Нийт 2,760.0 мянган төгрөгийн өртөг бүхий 4 ширхэг хөрөнгийг 2011 онд орлого авахдаа элэгдэл тооцох жилийг алдаатай тооцсон	1	2,760.0	-	-	1	2,760.0	1	2,760.0	-	-
Нийгмийн даатгалын байгууллагад тайлагнасан хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын дүн 581,130.7 мянган төгрөг, татварын байгууллагад илгээсэн цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого, шууд бус орлогод ногдуулан суутгасан албан татварын тайлан/ТТ-11/-д 559,119.9 мянган төгрөгөөр тайлагнаж, 22,010.8 мянган төгрөгийн зөрүүтэй	1	22,010.8	-	-	1	22,010.8	1	22,010.8	-	-
Тайлант оны 05 дугаар сард 3 ажилтанд олгосон илүү цагийн мөнгө олголтын тооцооллыг тулгахад 1 хүнд 12.6 мянган төгрөг, 2 ажилтанд 68.1 мянган төгрөг илүү олгосон.	1	80.7	-	-	1	80.7	1	80.7	-	-
Дүн	9	277,668.2	3	9,060.9	6	268,607.3	9	277,668.2	-	-

3.2 Аудитаар нийт 10,525.7 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс, 707.3 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 1 хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлж, 9,818.4 мянган төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Газар эзэмших эрхийн 2007 онд гарсан 0141753 дугаартай гэрчилгээ нь 2022 онд эзэмших хугацаа дууссан боловч газар эзэмших эрхийн гэрчилгээг сунгаагүй байна	1	-	-	-	-	-	1	-	-	-
“Эрчим хүчний хөгжлийн чиг хандлага ба үр ашигтай, байгаль орчинд ээлтэй технологи бүхий эх үүсвэрийн судалгаа” нэртэй бүтээлээр 2024 оны 01 дүгээр сарын 30-ны өдөр зохиогчийн эрхийн гэрчилгээг, “Монгол улсын дулааны эрчим хүчний салбарын экологийн баримжаатай хөгжлийн чиг хандлага” нэртэй бүтээлээр 2021 оны 11 дүгээр сарын 09-ний өдөр зохиогчийн эрхийн гэрчилгээг авахдаа зохиогчийн эрх эзэмшигчээр иргэнд олгосон байна. Эдгээр бүтээлүүд нь сүүлийн жилүүдэд хийсэн ажлуудын үр дүн гэж үнэлэн байгууллага дээр эзэмшүүлэх байтал хувь хүмүүсийн зохиогчийн эрхээр бүртгэсэн байна.	1	-	-	-	-	-	1	-	-	-
Дулаан техник, үйлдвэрлэлийн экологийн хүрээлэнгийн захирлын 2024 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн А/11 дугаар тушаалаар 2024 оны 2-р улирлын ажлын үр дүнгийн	1	9,818.4	-	-	-	-	1	9,818.4	-	-

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Дулааны техник үйлдвэрлэлийн экологийн хүрээлэнгийн 2024 оны санхүүгийн тайлан төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

нэмэгдлийг 20 ажилтанд 30-40 хувиар олгохоор тушаал гарсан боловч ажлын гүйцэтгэлийг үнэлсэн баримт байхгүй, нэмэгдэл олгох журам батлаагүй байна. Мөн 9,818.4 мянган төгрөгийн урамшуулал цалинг улирлын үр дүн гарахаас өмнө олгосон байна.										
Ээлжийн амралтын тооцоо бодолтыг түүвэрчлэн 4 ажилтныг тулгахад 1 ажилтанд 64.0 мянган төгрөг дутуу, 3 ажилтанд 707.3 мянган төгрөг илүү олгосон байна.	1	707.3	1	707.3	-	-	-	-	-	-
Өмнөх аудитаар өгсөн шийдвэрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулж, шалгагдагч байгууллага 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлэхээр Төрийн аудитын тухай хуульд заасан боловч төлөвлөгөөг 2024 оны 04 сарын 02-ны өдөр хугацаа хоцроож ирүүлсэн байна.	1	-	-	-	-	-	-	-	1	-
Дүн	5	10,525.7	1	707.3	-	-	3	9,818.4	1	-

3.3 АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудлаар 15,000.0 мянган төгрөгийн 1 зөрчилд албан шаардлага хүргүүлээ.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
			Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил						
Өмнөх оны аудитаар тайлант оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг батлуулаагүй, тайлан бэлтгээгүй гэсэн зөрчилд "Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайланг батлагдсан маягтаар бэлтгэж, хуулийн хүрээнд тайлагнах" гэсэн зөвлөмж өгсөн боловч зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байна.	1	15,000.0	1	15,000.0	-	-
Нийт дүн	1	15,000.0	1	15,000.0	-	-